

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

Д.СУНДУЙС РЭН -ДХИС-ИЙН УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН УДИРДАХУЙН УХААНЫ
ПРОФЕССОРЫН БАГИЙН ПРОФЕССОР, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

ХҮН БАРЬЦААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХНИЙ СУБЪЕКТИВ ШИНЖ

Товч агуулга: Хүн барьцаалах гэмт хэргийн бүрэлдэхүний зайлшгүй байх элементүүд субъектив шинжид хамаарах субъект, субъектив талыг авч үзлээ. Хүн барьцаалах гэмт хэргийн субъектив тал нь энэхүү хэргийн дотоод агуулга, мөн чанарын бодит илэрхийлэл болох сэтгэл зүйн агуулга, үүрх хэлбэл, субъектын сэтгэл зүйд тусгалаа олсон үйлдэж буй гэмт хэрэгтээ хандах оюун санаа, хүсэл зориг, гэмт хэрэг үйлдэхтэй шууд холбоотой субъектын сэтгэхүйн үйл ажиллагааны талаар судлахыг зорилгоо болголоо.

Түлхүүр үгс: Хүн барьцаалах гэмт хэрэг, хэрэг хариуцах чадвар, оюун санаа, зан үйл, хүсэл зориг, сэдэлт, зорилго

Keywords: *hostage-taking, kidnapping, liability, criminal intent, criminal behavior*

ОРШИЛ

Гэмт хэргийн бүрэлдэхүний субъектив тал нь бүхэлдээ гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн субъектын сэтгэхүйд болж буй дотоод үйл явцыг харуулаад зогсохгүй түүний ухамсар, оюун санаа, хүсэл зориг түүний үйлдэж буй нийгэмд аюултай үйлдэлтэй хэрхэн холбогдож байгааг илэрхийлнэ.

Гэмт хэргийн бүрэлдэхүний субъектив талд гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн үүрийн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүй, түүний улмаас учрах хор уршигт хэрхэн хандсан сэтгэхүйн харьцаа, үйл ажиллагааг хамрахаас бус гэмт хэрэг үйлдсэний дараа гэмт хэрэгтний үүрийн нэгэнт үйлдсэн гэмт хэрэгтээ хандаж буй сэтгэхүйн харьцааг илэрхийлдэггүй бөгөөд энэ нь гэмт хэргийн бүрэлдэхүүнд нөлөөлдөггүй зөвхөн шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахад харгалзан үзэх нөхцөл болдог.

Хүн барьцаалах гэмт хэргийн субъектив тал нь уг гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанарыг тодорхойлох нэг элемент бөгөөд гэмт хэрэг үйлдсэн гэм буруу, түүний хэр хэмжээ, хэлбэр, үүрх, сэдэлт зорилгоос энэ гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар хамаардаг.

Субъект:

Гэмт хэрэг хүний ухамсартай, нийгэмд аюултай зан үйл бөгөөд түүнийг гэмт хэрэг үйлдсэн этгээдгүйгээр авч үзэх боломжгүй юм. Гэмт хэргийн субъект эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэмт хэргийн бүрэлдэхүүнд зайлшгүй байх элементүүдийн нэг гэж үздэг. Гэмт хэргийн субъект байгаа явдал эрүүгийн хариуцлагын чухал нөхцөл бөгөөд “эрүүгийн хариуцлага нь юуны

Гэмт хэргийн бэрэлдэхүүний субъект гэдэг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн, үйлдсэн хэрэгтээ эрүүгийн хариуцлага хлээх чадвартай, Эрүүгийн хуулиар тогтоосон тодорхой насанд хүрсэн хувь хүнийг хэлнэ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага хлээлгэнэ” хэмээн гэмт хэргийн субъектын шинжийг тодорхойлсон байдаг. Эндээс үзэхэд эрүүгийн хариуцлага хлээлгэх субьектив үндэслэл нь гэмт хэрэг үйлдсэн этгээд болно.

Гэмт үйлдэл хүн барьцаалах гэмт хэргийн бэрэлдэхүүнтэй байгаа эсэхийг тодорхойлохын тулд уг хэргийг үйлдсэн этгээд хуулиар тогтоосон субьектийн шинж тэмдэгүүдийг агуулж байгаа эсэхийг тогтоох хэрэгтэй.

Хүн барьцаалах гэмт хэргийн бэрэлдэхүүний субьектын шинжийн хувьд: хувь хүн байх, хэрэг хариуцах чадвартай, 16 насанд хүрсэн байна. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн биечлэн хариуцлага хлээх зарчмыг баримталдаг учраас эрүүгийн хариуцлагыг гэмт этгээдийн гэр бүл, төрөл садны хүмүүст нь халдаан хэрэглэхийг хориглодог. Төрөөр хэлбэл, эдгээр хүмүүс нь энэ байдлаасаа болж гэмт хэргийн субьект болохгүй гэсэн үг юм.

Монгол улсын Эрүүгийн хуулиар өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадсан, бодит байдлыг зөв тусган үнэлэх чадвартай, төрөөр хэлбэл хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага хлээлгэнэ. Гэмт хэрэг үйлдэх үедээ үйлдлийнхээ нийгмийн хор аюулыг ухамсарлан, жолоодож чадахгүй, хэрэг хариуцах чадваргүй хүн гэмт хэргийн субьект болж чадахгүй, тиймээс гэмт хэргийн бэрэлдэхүүнийг үгүйсгэж болно.

Хүний үйл хүдлэлийг тодорхойлогч сэтгэцийн үндсэн функциуд бол оюун ухаан, сэтгэлийн хүч хоёр юм. Эдгээр нь бодит нөхцөл байдал, амьдралын материаллаг боломж болон хувь хүний төлөвших нийгмийн орчноор илэрхийлэгдэнэ.

Гэсэн хэдий ч оюун ухаан, сэтгэлийн хүч хоёрын идэвхитэй өргийг үгүйсгэх аргагүй. Идэвхитэй өөрөг субьектын өөрийн үйлдлээ ухамсарлах, өөрийн үйлдлээ ухамсартайгаар удирдах чадвараар илэрнэ. Энэхүү чадварыг эзэмшсэн хүнийг хэрэг хариуцах чадвартайд тооцно.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн томъёололоор хүний хэрэг хариуцах чадваргүйг зөвшөөрөхийн тулд эмнэлэгийн ба хуулийн гэсэн хоёр шалгуур байх ёстой.

“Хүн өвчтэй гэдгээсээ биш харин өвчин нь сэтгэн бодох эрх чөлөө ба үйлдлийн аль нэг хэлбэрийг сонгох эрх чөлөөг боогдуулсанаас болж хэрэг хариуцах чадваргүй болдог”².

Хүн барьцаалах гэмт хэргийн объектив талын онцлогууд, үйлдэл, аргын хүрээнд сэдэлт ба зорилго нь хэргийн субьектээс их ч, бага ч сэтгэхүйн болоод сэтгэлийн хүчний хүгжлийг шаарддаг. Энэ нь хүн барьцаалах үйлдлийг хэрэг хариуцах чадваргүй хүн үйлдэх бараг боломжгүй болгож байгаа юм. Гэхдээ ямар ч гэсэн хэрэг хариуцах чадваргүй этгээд хүн барьцаалах тохиолдлыг үгүйсгэж болохгүй.

Энэ талаар Монгол улсын Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдлын улмаас иргэний илдлийг бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт Тэмт хэрэг илдэх нөдөө хэрэг хариуцах чадваргүй байсан хөнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ” гэж заажээ. Гэмт хэрэг илдсэн этгээдийн хэрэг хариуцах чадвартай эсэхийг сэтгэц эмгэг зүйн болон хууль цаазны шалгуурыг үндэслэн тогтооно.

Энэ гэмт хэргийг илдсэн этгээд хэрэг хариуцах чадвартай, 16 нас хүрсэн буюу түүнээс дээш настай хүн байхыг ойлгоно. Гэмт этгээдийн насыг иргэний үнэмлэх, хүрсний гэрчилгээ болон холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн тогтоодог. Хэрэв түүний хэдэн настайг гэрчлэх бичиг баримт байхгүй бол шүүх эмнэлгийн шинжилгээ томилж насыг тогтоолгоно. Шүүх эмнэлгийн дүгнэлтэд уг этгээдийн насыг харьцангуйгаар авч үзсэн байвал доод хэмжээг нь баримтлах ёстой.

Хүн барьцаалах гэмт хэргийн субъект барьцааны хүнийг суллах болзол болгон тодорхой илдэл хийлгэх, илдэл хийхээс татгалзуулах зорилгоор тэр (улс), байгууллага, хүнд хүч хэрэглэхээр заналхийлж барьцаалсан гэмт үйл ажиллагааг хэрэгжүүлсэн буюу түүнд хамтран оролцогчийн хувиар оролцсон нийтлэг субъектийн шинжийг агуулсан хүн байна.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектыг тодорхойлохын Эрүүгийн эрх зүйн ач холбогдол нь: 1) Амьдралд гарсан хэрэг нь гэмт хэрэг мөн эсэх, түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй эсэхийг тогтооход 2) Тухайн хэргийг субъектээс нь хамаарч Эрүүгийн хуулийн тодорхой зүйл, хэсгээр зүйлчлэх 3) Тус бүр гэмт хэргүүдийг субъектын шинжийг нь харгалзан зөв зүйлчлэх 4) Эрүүгийн хариуцлагын төрлөөс сонгон хэрэглэх, ялыг ялгамжтай оногдуулахад оршино.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3.1 дүгээр зүйлд тодорхойлсноор “хоёр, түүнээс олон хүн гэмт хэрэг илдэхэд санаатай нэгдсэнийг гэмт хэрэг хамтран илдэх”, “гүйдэтгэгч, зохион байгуулагч, хатгагч, хамжигчийг гэмт хэрэг хамтран илдэгчид тооцох”³-оор заажээ. Хүнийг барьцаалах гэмт хэргийг илдэхээр бэлтгэсэн, завдсан буюу үүрээр хэлбэл, тус бүр гүй гэмт хэргийн шатанд баригдсан этгээдийг мөн гэмт хэргийн субъектээр тооцно.

Харин дипломат дархан эрх, эрх ямба эдэлж байгаа болон дагаж мөрдөж байгаа хууль, олон улсын гэрээний дагуу Монгол улсын шүүхэд эрүүгийн хэргийн талаар харъяалалгүй бусад этгээдээс уг гэмт хэргийг илдвэл түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээ дагуу шийдвэрлэх журамтай.

Субъектив тал:

Гэмт хэрэг хүний физиологийн болон ухамсар, сэтгэхүйн үйл ажиллагааны нийлбэр, хүний нийгэмд аюултай зан үйл бүрд гэмт хэргийг зөвхөн түүний гадаад хэлбэр буюу гэмт илдэл, эс илдэхгүй, хор уршиг зэрэг объектив шинжид тулгуурлан дүгнэлт хийх нь үр дүндгүй явдал болно.

Гэмт хэргийн объектив тал гэмт хэргийн гадаад тодорхойлолт (нийгмийн аюултай илдэл, эс илдэл, нийгмийн аюултай үр дагавар, шалтгаант холбоо, байрлал, цаг хугацаа г.м.) бол субъектив тал түүний дотоод (объектив талын хувьд) тодорхойлолт болно. Үүрээр хэлбэл

гэмт этгээд өйлдсэн гэмт хэрэгтээ хандах сэтгэцийн хандлага гэж үзэж болно.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг нь хэн нэгэн этгээд өйлдсэн гадаад хэлбэрээрээ хуульд туссан шинжтэй тохирох түүнийг эрүүгийн хариуцлага хлээлгэж болохгүй.⁴ Субъектив тал - гэмт хэргийн өйлдлийг дагалдах сэтгэцийн бүх өйл ажиллагаа бүрд оюун ухааны, сэтгэлийн ба сэтгэл хөдлөлийн өйл явцын бүрэн нэгдэл, харилцан уялдаанд явдаг болно⁵. Субъектив талын ач холбогдол бол түүний тусламжтайгаар гэмт хэргийг нарийн ангилах, хоорондоо тусгай бэрэлдэхүүнийг зааглах, хариуцлагыг хөн бүрт тохируулан оногдуулахад оршино.⁶

Гэмт хэргийн бэрэлдэхүүний субъектив талыг зөв тогтоосноор тухайн этгээд гэм буруутай эсэх, гэм буруугийн ямар хэлбэрээр гэмт хэрэг өйлдсэн эсэх, өөрийн гэмт өйл ажиллагаагаа хэрхэн ойлгож ухамсарласан эсэх зэрэг гэмт этгээдийн гэмт өйлдэл, эс өйлдэхөйдээ хандах сэтгэл зүйн харьцааг тогтоох, тухайн хэрэгт эрүүгийн хариуцлага хлээлгэх өндэслэл байгаа эсэх, гэмт этгээдийн өйлдлийг зөв зөйлчлэх, тусгай гэмт хэргүүдийг ялгаж зөйлчлэх, ялыг ялгамжтай оногдуулахад ач холбогдолтой юм.

Гэмт хэргийн бэрэлдэхүүний субъектив тал гэж гэмт этгээдийн өйлдсэн нийгэмд аюултай өйлдэл, эс өйлдэхүй, түүний улмаас учрах хор уршгийг хэрхэн ойлгож ухамсарласан, тэдгээрт хэрхэн хандсан сэтгэл зүйн дотоод харьцаа болох гэм буруу, түүнийг тодорхойлох гэмт хэрэг өйлдсэн сэдэлт, зорилго, гэмт хэрэг өйлдэх өөийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал зэрэг субъектив шинжийг тодорхойлох гэмт хэргийн бэрэлдэхүүний бие даасан элемент юм.

Хүний нийгэмд аюултай зан өйлд эрүүгийн хариуцлага хлээлгэх субъектив өндэслэлийг тогтоохын нэг гол элемент бол субъектив тал мөн.

Гэмт хэргийн субъектив талыг бүрдүүлдэг шинж тэмдэгүүдэд гэм буруу, сэдэлт, зорилго болон гэмт этгээдийн гэмт хэрэг өйлдэх өөийн сэтгэл хөдлөлийн байдал хамаарна. Гэм буруутай байх явдал субъектив талыг тодорхойлох өндсэн шинж юм. Гэм буруу гэж гэмт этгээдийн өөрийн нийгэмд аюултай өйл ажиллагаа тухайлбал, гэмт өйлдэл, эс өйлдэхүй, хор уршгаа хэрхэн ойлгож ухамсарласан байдал, тэдгээрт хэрхэн хандсан сэтгэл зүйн дотоод харьцааг хэлнэ.

Гэм буруу нь санаатай болон болгоомжгүй гэсэн хоёр хэлбэртэй. Гэмт хэрэг өйлдсэн этгээд өөрийн өйлдэл буюу эс өйлдэхүйн нийгмийн хор аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүнээс учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдаас мэдсээр атлаа хссэн, эсхл тэр хор уршигт зориуд хөргэсэн бол гэмт хэрэг санаатай өйлдсэн гэж үзнэ. Харин гэмт хэрэг өйлдсэн этгээд өөрийн өйлдэл буюу эс өйлдэхүйн нийгмийн хор аюулын шинж чанарыг ухамсарлаж, түүний улмаас учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдаас мэдсээр атлаа түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцож өйлдсэн, эсхл тэрхүү хор уршгийг урьдаас мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан атлаа мэдэлгүй өйлдсэн бол гэмт хэрэг болгоомжгүй өйлдсэн гэж үздэг. Хүнийг барьцаалах гэмт хэргийн бэрэлдэхүүний субъектив талын гэм буруу нь шууд санаатай хэлбэрээр илэрнэ. Монгол улсын Эрүүгийн хуулийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “өөрийн өйлдсэн, эс өйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг мэдсэн атлаа түүнийг хсч өйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хөргэсэн бол санаатай гэмт хэрэгт тооцно” гэж заасан.

4. Содовсүрэн Б. “БНМАУ-ын Эрүүгийн эрх” ерөнхий анги. -Уб. 1969. 84 дэх тал.

5. Брайнин Я. М. Уголовная ответственность и ее основания в советском уголовном праве. С. 227-228.

6. Курс советского уголовного права: В 5 т. /Под ред. Н. А. Беляева., М. Д. Шаргородского. Л., Т. 1. 1968. С. 404.

7. Түүний мэдээлэл (эмхтгэл). -Уб., 2016. № 07.

Ингэж эзэх үндэслэл хүнийг барьцаалах гэмт хэрэг барьцаалагч этгээдийн тодорхой зорилго бүхий идэвхитэй үйлдлийн үр дүнд үйлдэгддэг. Тиймээс энэ гэмт хэрэг шууд бус санаатайгаар юмуу, болгоомжгүйгээр үйлдэгдэх ямар ч боломжгүй юм.

Хүн барьцаалах гэмт хэрэг тэр, байгууллага, иргэнийг ямар нэг үйлдэл хийх эсвэл ямар нэг үйлдлийг үл хийлгэхээр тулган шахах зорилгоор үйлдэгддэг бүгд зорилго нь бүрэлдэхүний элементийн хувьд шууд чиглэсэн санаа байгааг илтгэнэ. Тодорхой зорилго агуулсан гэмт этгээд шаардлагыг нь биелүүлж чадах хүмүүс, байгууллагад санаатай эсвэл тулган шаардлага тавьдаг.

Ийм зорилгодоо тааруулан товлосон эсвэл таарсан хүнийг барьцаанд авч нэгдүгээрт барьцааны хүнийг чөлөөлөх сонирхолтой, хоёрдугаарт түүний шаардлагыг биелүүлэх боломжтой (эд хүрнгийн эсвэл үүрийн албан тушаал болон мэргэжлийн хувьд) тодорхой хүмүүст шаардлага тавьдаг.

Хэрэв гэмт хэрэгтэн хууль бусаар хил нэвтрэх гэсэн эцсийн зорилго тавьсан бол түүндээ тохирсон арга, барьцааны хүмүүс (ихэнхдээ зорчигчдыг сонгох бүгд тэдний аюулгүй байдлыг хүлгийн ахмад хариуцна) ба шаардлага тавьж болох хүмүүсийг (хүрээр хэлбэл агаарын болон далайн хүлгийг удирдаж байгаа эсвэл тээврийн хэрэгсэл олгохыг шийдэж чадах) сонгоно.

Хэрэв хүн барьцаалах хэргийн зорилго хорих газраас оргох явдал бол гэмт хэрэгтэнүүд ихэнх тохиолдолд хорих газарт ажилладаг эмэгтэйчүүд буюу эмнэлгийн ажилтнууд, багш нар, нягтлан бодогчид, шалгагчид, дэлгүүрийн ажилчдыг барьцааны хүмүүсээр сонгож хорих газрын захиргаанд шаардлага тавьдаг.

Хүн барьцаалах хэргийн субъектив талын зайлшгүй шинж бол тулган шахах замаар санасандаа хүрэх зорилго болохыг илтгэж байна. Гэмт этгээд бусад хүнийг хүчээр барьж барьцаалан, алж хороох, бие махбодид гэмтэл учруулах, өргэлжлүүлэн барьцаанд байлгахаар заналхийлж, гуравдагч этгээдээр үүрийн шаардлагыг биелүүлэхийг барьцааны хүнийг суллах нөхцөл болгож байгаагаа ухамсарлаж байдаг.

Гэм буруугийн шууд санаатай хэлбэрийг гэмт этгээд үүрийн үйлдлийн улмаас учирч болох, учруулахыг зориуд хүссэн хор уршгийг хэрхэн төсүүлж байгаа байдал, хэр хэмжээнээс хамаарч а) тодорхой бус шууд санаа б) тодорхой шууд санаа в) сонгох шууд санаа гэж ангилдаг.

Тодорхой бус шууд санаа гэж гэмт этгээд үүрийн үйлдлийн эцэст бий болох хор уршгийн талаар тодорхой төсөөллөгүй, хор уршиг учруулна гэсэн санаа бодолтойгоор гэмт хэрэг үйлдсэн байхыг хэлнэ. Жишээлбэл: Т, Б, С гэгч хоригдлууд шоронгоос оргож явахдаа нэгэн хүнсний дэлгүүрт байсан хүмүүсийг барьцаанд авч нисдэг тэрэггүйг шаардсан байна. Гэмт этгээдүүдийн барьцаалсан дэлгүүрт нилээд олон хүн байсан бүгд тэд яг хэдэн хүн барьцаалахаа урьдчилан мэдэх боломжгүй байсан нь илэрхий бүгд гагцхүү тэнд байгаа хүмүүсийг л барьцаалах бодолтой байсан. Энэ хэрэг дээр гэмт этгээдүүд хор уршигтаа тодорхой бус шууд санаатайгаар хандсан байна.

Тодорхой шууд санаа гэдэг гэмт этгээд урьдаас тодорхой нэг хор уршгийг учруулахыг хүсэж үйлдсэн байхыг хэлнэ. Жишээлбэл, эрхэлсэн ажилгүй А, Г нар томоохон компанийн захирлын охин Ч-г барьцаанд авч, түүний эцгээс мөнгө нэхэх зорилготой байсан бүгд түүнийгээ ч үлгэлдүүлсэн байна. Гэмт этгээд А, Г нар чухам хэнийг барьцаанд авахаа сайтар мэдэж байсан буюу хүрээр хэлбэл, урьдаас тодорхой нэг хор уршиг учруулахыг хүсэж үйлдсэн.

Энэ хэрэг дээр гэмт этгээдний илдэлд гэм буруугийн тодорхой шууд санаа илэрч байна.

Сонгох шууд санаа гэж гэмт этгээдний илдлийн эцэст учирч болох хэд хэдэн хор уршгаас (халдлагын зйлээс) урьдаас зориуд нэгийг сонгож хсэж илдсэн байхыг хэлдэг. Жишээ нь. А гэгч этгээд банк дээрэмдэж байтал цагдаа нар ирж банкыг сэлсэн байна. Тэрбээр зугтахын тулд тэнд байсан хмссээс зvxн гадаадын нэг иргэнийг барьцаанд авсан бгд гадаадын иргэнд цагдаагийнхан ил анхаарал тавина гэж бодсонтой холбоотой байв. Энэхүү А гэгч этгээдийн илдэл дээр дгнэлт хийхэд: А тэнд байсан хмссээс хэнийг ч барьцаалах боломжтой байсан, гэвч тэндээс зvxн гадаадын хнийг л сонгож барьцаанд авчээ.

Гэм буруугийн шууд санаатай хэлбэрийг гэмт этгээдийн гэмт хэрэг илдэх гэсэн санаа бодол нь хэзээ сч бий болсон, тнийгээ хэрхэн биеллснээс хамаарч а) урьдаас тлвлсн шууд санаа б) гэнэт ссэн шууд санаа гэж ангилж здэг.

Урьдаас тлвлсн шууд санаа гэдэг гэмт этгээдийн гэмт хэрэг илдэх гэсэн санаа бодол гэмт хэрэг илдэхээс нилээд хэсэг цаг хугацааны мн сч бий болсон бгд гэмт этгээд тэрхүү санаа бодлоо хэрэгжлэхийн тулд урьдаас тлвлсн ил ажиллагаа хийсний эцэст (бэлтгэл шинжтэй) гэмт хэрэг илдсэн байхыг хэлнэ. Гэм буруугийн энэ хэлбэр уг этгээдийн сэтгэхий нь нийгмийн эсрэг ямар нэгэн хорт сэдэлтэд ндэслэгдсэн тусгай зорилго агуулсан байдгаараа гэм буруугийн хамгийн аюултай хэлбэр болдог.⁸ Тухайлбал, барьцаанд авах хнээ урьдчилан сонгож, тнийг хорих тусгай байр сав бэлтгэж, ямар хэрэгслээр дамжуулж болзол тавихаа нарийн бодож тооцоолсны ндсэн дээр тодорхой хнийг барьцаанд авч байгаа явдал бол урьдаас тлвлсн шууд санааны илрэл юм.

Гэнэт ссэн шууд санаа гэдэг гэмт этгээдийн гэмт хэрэг илдэх гэсэн санаа бодол нь тухайн гэмт хэрэг илдэх е, цаг мч, газар гэнэт сч, тэрхүү санаа бодлоо тэр дороо хэрэгжлсэн байхыг хэлнэ. Жишээ нь. Мааньт дахь чанга дэглэмтэй хорих ангийн хоригдол Ц, Э, О, Б нар гуравдугаар сарын 3-ны (1994 он Н.Э) 01 цагийн ед архидан согтуурч хорих ангийн эмнэлэгийн тогооч Ц-г зодож танхайрчээ.

Тэднийг зохицуулахаар очсон хянагч Х, Э нарыг мн зодож улмаар хлж барьцаанд авчээ. Хутга, заазуур, схээр зэвсэглэсэн дээрх хоригдлууд хоёр цаг шахам хугацааны дараа хянагчдыг сулласан байна. Эдгээр хоригдлууд анх хянагчдыг барьцаанд авъя гэсэн санаа бодол байгааг нь тодорхой бгд танхайрах явцад дээрх гэмт санаа тржээ. Иймээс эдгээр хоригдлуудын илдэлд гэнэт ссэн шууд санаа илэрч байна.

Эрлийн хэрэг, материалууд, тнчлэн хн барьцаалсан хэргийн тухай хэвлэл мэдээлэл дээр хийсэн судалгаагаар энэ трлийн хэргийг урьдаас бэлтгэж хийдгээс гадна гэнэт трсн санаагаар хийдгийг тогтоосон. нээс хамааран хн барьцаалах хэргийн зорилгын ялгаануудыг илрлжчадсан. Урьдаас бэлтгэсэн санаагаар хн барьцаалах хэрэг илдэхдээ дараах зорилгыг тавьдаг: а) хорих газраас, шхийн танхимаас оргох, б) хил давах, в) барцааны тлбр авах, г) улс трийн шаардлага тавих, д) шгч, мрдгч, прокурор, экспертийн шийдвэрт нлл х г.м. е) ндэстэн хоорондын мрглдний ед олзлогсдыг солилцох зэрэг байж болно.

Гэнэт ссэн санаагаар хн барьцаалах хэргийг гол тлв трийг эсвэл гэмт хэрэг илдсэн бусад хнийг хамгаалах, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад баригдах ба мрдгдх, гэмт хэрэгтнийн хувьд тун тааламжгй нхцл байдалд илддэг.

Ямар боловч хэн барьцаалах хэргийн ангилал санаа бэрэлдэн тогтох цаг иэс хамаарахгүй. Харин гэмт хэргийг урьдаас бодож тлвлж хийсэн гэмт этгээд, гэнэт өссэн санаагаар уг гэмт хэргийгйлдэгчээс ил аюултай байдаг.

Нэгдгээрт, хэлэлцээрийн р днд гэнэтийн санаагаар хэрэгйлдэгчийг цаашидйлдэх гэмт хэргээс татгалзуулж, барьцааны хнийг суллуулахаар итгэлж болно. Хоёрдугаарт, гэмт этгээдийнйлдэл ихэнхдээ ил, зориудын шинжтэй байдаг тул хууль сахиулах байгууллагынхан барьцааны хмсийг чллх хд хялбар байх боломж байдаг.

Харин эхний трлийн гэмт этгээд ихэвчлэн бодож боловсруулж, нууцаар ажилладаг, барьцааны хмсийг л мэдэгдэх газар нуудаг, гэмт этгээдийн хувийн шинж тодорхой хугацаа хртэл л мэдэгддэг (барьцааны тллс авах зорилгоор хн барьцаалсан тохиолдолд гэмт хэрэг илрэхгүйлдэж болно) тул урьдаас санаатайгаарйлдсэн эсвэл гэнэт трсн санаагаарйлдсэн гэдгийг ял шийтгэл оноохд харгалзандэг.

мн тэмдэглэсэнээр хн барьцаалах хэрэг олон объекттой гэмт хэрэгт хамаарна. Нэг цаг хугацаанд хэд хэдэн объектод (ндсэн ба нэмэгдэл) халдсанйлдэл нь уг санааны агуулгыг илрлэхд халдлагын объект болгонд хандсан гэмт этгээдийн сэтгэцийн хандлагад анализ хийхийг шаарддаг⁹.

Санаа бодол нь оюун ухааны ба сэтгэлийн хчний элементд байгааг илэрхийлнэ. Ингэхдээ эхнийх нь санааны агуулгыг, хоёрдахь нь тний чиглэсэн чиглэлийг тодорхойлно¹⁰. Санаа бодлын оюун ухааны элемент бол хн өрийнйлдлийн нийгмийн аюулыг хлээн звшлрч, нийгмийн аюултайр дагаварыг урьдчилж харах явдал юм.

Хн барьцаалсан гэмт этгээдийн ухамсарт: а) нийгмийн аюулгүй байдалд халдсан, б) хний амь нас, эрл мэнд тнчлэн хний хувийн эрх чл, халдашгүй байдалд халдсанйлдэл хамаарна.

Хн барьцаалах гэмт хэргийн оюун ухааны элементийн агуулга бол гэмт хэргийн объектив талын бх шинж тэмдэгийг гэмт этгээд ухамсарлах явдал болно.йлдэж буййлдлийн аюул ба тний хуулийн эсрэг гэдгийг ухаарах явдал мн хамаарна. Ийм маягаар хн барьцаалах еийн шууд санаа бодлын оюун ухааны элементийг томьёолохдоо уг субъект гэмт хэрэгйлдэхдээ нийгмийн аюулгүй байдлыг рчиж, бусдыг хчээр барьцаалснаараа хний хувийн халдашгүй байдал, эрх чл, амь нас, эрл мэндэд халдаж буйгаа ухамсарлаж байгаа гэжзэж болно.

Санаа бодол звхнйлдлийн нийгмийн аюул ба хуулийн эсрэг гэдэгт хандах оюун ухааны хандлагаас гадна тодорхой сэтгэлийн хчний хандлагаар тодорхойлогдоно. Ухамсар хрээлэн буй ертнийг ямар байгаагаар илэрхийлдэг бол сэтгэлийн хч тнийг рчлхд чиглэгдэнэ. Шууд санаа бодлын сэтгэлийн хчний шинж тэмдэг нь хн барьцаалж “гуравдагч этгээддэд” шаардлага тавих гэсэн субъектийн хслээр илэрхийлэгдэнэ.

Хн барьцаалах хэргийн сэтгэлийн хчний мн чанар тавьсан зорилгодоо хрэх идэвхтэй тэмлэлд оршино. Гэхдээ хн барьцаалж тнийг барьцаанд байлгах явдал гэмт хэрэгтний зорилго биш харин зорилгодоо хрэх арга хэрэгсэлтр, байгууллага эсвэл иргэнээр ямар нэгэнйлдэл хийлгэхгүй бол ямар нэгэнйлдэл хийхээс татгалзуулахаар хчлэн тулгах... “ гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

9. Гаухман Л. Д. Проблемы уголовно-правовой борьбы с насильственными преступлениями в СССР. С.100.

10. Дагель П. С., Котов Д. П. Субъективная сторона преступления и ее установление. Воронеж, 1974. С. 83.

Хүн члэн тулгалт гэмт хэрэгтэнд хэрэгтэй чиглэлийг дэмжих сэтгэл зүйн хүчирхийллийн онцгой төрөл болдог.¹¹ Хүн члэн тулгалт гэж хүчээр нөлөөлөх хязгааргүй олон аргыг хэлнэ. Энд: шаардлага хүлээж авсан талд, мөн барьцааны хүнд шууд хандсан төрөл бүрийн заналхийлэл багтана.

Хүн барьцаалах хэрэг хэлбэрийн бүрэлдэхүүнд хамаардаг, өөрөөр хэлбэл энэ гэмт хэргийг төгссөн гэж зэхийн тулд нийгмийн аюултай үр дагаврыг хүлээх шаардлагагүй. Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй (гэмт хэргийн) үр нөлөө нь гэмт хэргийн бүрэлдэхүүний хил хязгаарын гадна байгаа учир гэмт хэргийн ангилалд сэтгэцийн хандлага ямар ч ач холбогдолгүй. Шууд санаа бодлын агуулга бол “уг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж тэмдэг болох тэр л обьектив шинж тэмдэгт хандах субъектийн сэтгэцийн хандлагыг” бий болгодог¹².

Ийм ч учраас хүн барьцаалах үйлдэл гуравдагч этгээддэд шаардлага тавьсанаар төгсгөл болно. Учир нь, яг энэ мөчид гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектив тал бүрэн биелэгдэнэ. Өмнө тэмдэглэсэнчлэн, хэрэв гэмт хэрэгтэн хүнийг бариад төнийг барьцаалагдсан хүнээр зарлаж амжаагүй бол төний үйлдэл эрх чөлөөг нь хууль бусаар хасах, харин баригдсан хүнийг барьцааны хүнээр зарлах санаархал нь батлагдсан бол хүн барьцаалах гэмт хэргээр ангилна.¹³ Хүн барьцаалах үеийн гэмт этгээдийн үйлдлийн эх үндэс сэдэлт нь гэмт хэргийн зорилготой салшгүй холбоотой бүгд гэмт этгээд барьцааны хүнийг суллах нөхцөл болгосон үйлдлээр илэрдэг.

Сэтгэл судлалын шинжлэх ухаанд сэдэлт гэдэгт хувь хүний эрч хүчийг өдөгчид, хүдлөгчид хүч, хүний үйлдлийн эх үндэс гэж үзэж болох юм.

Хүн барьцаалах гэмт хэргийн сэдэлтийг 2 ангилж болох юм. 1) ямар нэгэн учир шалтгаанаар буюу гуравдагч этгээдэд нөлөөлөх зорилгоор хувь хүнийг барьцаалах, ийм тохиолдолд барьцаалагдагч - барьцааны хүн гэж нэрлэдэг 2) Гэмт этгээд өөрийн хүсэл зориг, сэтгэл хүдлөллөөр хувь хүнийг барьцаалах, ийм тохиолдолд хохирогч - барьцааны хүн гэж нэрлэдэг¹⁴. Энэ тохиолдолд эсрэгээр гуравдагч этгээдтэй холбоо тогтоохоос зайлсхийх гэмт этгээд жигшил, зөв үлгэр болгох зорилгоор хүн барьцаалдаг байна.

Хүн барьцаалах хэргийг үйлдэж буй хүний сэтгэлийн хүч юунд чиглэгдэж байгааг тайлбарлахын тулд тэр хүн тодорхой үйлдлийг үйлдэхдээ юуг удирдлага болгосоныг мэдэх хэрэгтэй. Ийм учраас хүн барьцаалах үеийн сэдэл ба зорьсон зорилго (гуравдагч этгээдийг) юунд хүчлэн шахахаар санаархаж байгааг тогтоох нь чухал. Сэдэл үйл ажиллагааг бодитойгоор өдөгчийн тулд сэдэлд тохирсон тодорхой зорилго тавих ёстой. Чухамдаа зорилго сэтгэцийн дотоодод орших хүсэл, мэдрэмжийг хөдлөгчид сэдэлд хувиргадаг. Үйл ажиллагааны төрөл, төний арга барил, хэрэгсэл зорилгоос хамаардаг. Сэдлийн тухай ярихдаа төнийг зорилгоос салгаж болохгүй. Тэдгээрийн хооронд үргэлж дотоод холбоо оршдог. Хүн барьцаалах үйлдлийн сэдэл бол хүн барьцаалах арга хэрэгслээр тодорхой зорилгод хүрэх гэсэн ухамсартай өдөгч юм.

Хүн барьцаалах хэргийн хувьд сэдэлт, зорилго их олон янз байх хэв шинжтэйг практик харуулж байна. Энэ гэмт хэргийн сэдэлтүүдийн дийлэнх нь явцуу хувийн сонирхол болон өөр бусад санаархал байдаг.

11. Иванов В. Ф. Уголовно-правовая оценка понуждения. Саратов, 1986. С.62.

12. Рарог А. И. Умысел в формальных преступлениях при приготовлении, покушении и соучастии //Сов. гос. и право. 1977. №1. С. 65.

13. Никифоров Б. С. Об умысле по действующему уголовному законодательству //Сов. гос. и право. 1965. № 6. С. 27

14. Vecchi Gregory, M. 2006. Assessing organizational group conflict in law enforcement hostage/barricade management. PhD diss., University of Michigan.

Энэ ангиллын эрмэлзийн хэргийн судалгаагаар хувийн явцуу сонирхлын төгөөмэл хэлбэр барьцааны хөнийг чөлөөлөх төлбөрт ихээхэн хэмжээний мөнгө авах гэсэн санаархал гэдгийг харуулдаг. Жишээ нь 2001 оны 5-р сарын 27-ны өдөр Филиппин улсын мөнд хэсэгт орших Исламын салан тусгаарлагч террорист бөлөг Абу Саияф-ын дайчид Бурнхамын гэр бөлийг бусад хөмөсийн хамт барьцаалсан байна. Барьцаалагдсан хөмөсийн ихэнх нь зэвсэгт бөлөглөлийн гарт амьсрэгдэж, зарим нэг нь төлбөр төлж амьсмуларчээ. Харин Бурнхамын гэр бөлийн хоёр нэг жил хэдэн хоногийн турш тус бөлөглөлийн барьцаанд байв. Тэднийг нэг сая ам долларын төлөх болзол тавин барьцаалсан байжээ. Хэдийгээр 300.000 ам долларын төлбөр төлсөн боловч барьцаалагчид тэднийг суллахаас татгалзжээ. 2002 оны 06-р сарын 07-ны өдөр Филиппиний арми барьцааны хөмөсийг аврах ажиллагаа явуулах өээр армийн албан хаагчдын зарим нь буудуулж амьсэрдэж, Грасиа Бурнхам шархадсан ч барьцаанаас суллагаж чадсан байна.

Хүн барьцаалах хэргийн субъектив талыг авч өзсөнээр энэ нь шууд санаа бодол, тусгай зорилгоор тодорхойлогдоно гэдгийг тэмдэглэх нь зөйтэй. Өөрийн өйлдлийг өйцэтгэхдээ гэмт этгээд тодорхой талуудыг ямар нэг өйлдлийг хийж өйцэтгэх эсвэл хийж өйцэтгэхээс татгалзахыг болзол болгон барьцаалж буй барьцааны хүн болон бусад хөмөс, байгууллагад хохирол учруулж болзошгүй ба зайлшгүй ийм маягаар ажиллана гэдгээ ухамсарласан байдаг.

Гэмт этгээд хүн барьцаалах хэргийг өндсөн зорилго биш харин эцсийн зорилгодоо хүрэх эхний бөгөөд зайлшгүй өөшөт хэмээн өздэг байна. Ийм ч учраас барьцааны хүний эсрэг сэтгэцийн болон бие махбодийн хүчирхийлэл хэрэглэх, эрх чөлөөг хязгаарлаж, сонгосон талуудад нөлөөлөх замаар эцсийн зорилгодоо хүрэх, гэхдээ зайлшгүй бөгөөд өр дөнтэй арга хэрэгсэл гэж гэмт этгээд ухамсарлаж байдаг. Хүн оюун санаа, хүсэл зоригийн хувьд чөлөөтэй байж, улмаар өөрийн хийх гэж буй өйлдлийн нийгэмд хортой, эсвэл ашигтай шинжийг ухамсарлан ойлгосны өндсөн дээр сонголт хийх чадвартай байхдаа хийсэн өйлдлийнхээ төлөөл хариуцлага хүлээх өстой.

Аливаа санаатай ба болгоомжгүй хэлбэрээр өйлдэгдсэн гэмт хэрэг оюун санааны болон хүсэл зоригийн шинжийг агуулж байдаг. Хүн барьцаалах гэмт хэрэг гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр өйлдэгддэгийг мөн дурдсан билээ.

Гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр өйлдэгддэг гэмт хэрэг дээр оюун санааны шинж нь гэмт этгээд өөрийн өйлдлийн нийгмийн хор аюулын шинж чанарыг ухамсарлаж, төөний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах нь зайлшгүйг урьдчилан мэдэж байдагт оршдог. Харин хүсэл зоригийн шинж нь гэмт этгээд өөрийн гэмт өйл ажиллагааны улмаас учрах хор уршгийг бий болгохыг хүсэж, төөнийгээ хэрэгжөөлсөн байдгаар илэрнэ. Тухайлбал, Д гэгч этгээд нэгэн хөхдийг барьцаанд авч, төөний эцэг, эхээс 10 сая төгрөг өгөхийг шаардсан байна. Энд гэмт этгээд Д хүн барьцаалах өйлдэл бол хууль бус, гэмт хэрэг болно гэдгийг мэдэж байдагт оюун санааны шинж, гэвч Д өөнийг тоолгүй шунахайн сэдэлтээр хөхдийг барьцаалж, золионд мөнгө шаардаж байгаад хүсэл зоригийн шинж оршиж байна. Аливаа зан өйлийг зөв өнэлэхэд төөний сэдэлт, зорилгыг харгалзахгүй байх ямар ч боломжгүй юм. Энэ зан өйл эрмэлзийн эрх зөйн хамгаалалтад бөрөн хэмжээгээр хамаарна¹⁵.

Хүний өйл ажиллагаа ухамсартай болохыг тодорхойлдог субъектив хүчин зөйл нь сэдэлт, зорилго байдаг. Учир нь хүний ухамсартай өйл ажиллагаа ямагт тодорхой сэдэлтэд өөдэгдэн, эцсийн өр дөн болох зорилгод чиглэж байдаг. Өөрөөр хэлбэл, сэдэлт, зорилгогүй ухамсартай

Энгийн ажиллагаа гэж байдаггүй. Энгийн адил хэргийн нийгэмд аюултай зан эл болох гэмт хэрэг нь тодорхой гэмт сэдэлтэд өдөгдөн, эцсийн үр дүнд болох хор уршгийг бий болгож байдаг.

Гэмт хэрэг өйлдсэн сэдэлт, зорилгыг зөв тогтоох зөвхөн гэм буруугийн санаатай хэлбэрээр өйлдэгддэг гэмт хэрэг дээр эрхийн эрх зүйн ач холбогдолтой. Учир нь гэмт хэргийн зорилго ба сэдэлтийг хангалттай судалж шийдвэрлэхгүйгээр аливаа санаатай гэмт хэргийн тодорхой шалтгааныг нээж илрүүлэх, эрхийн хуулийн заалтыг зөв хэрэглэх боломжгүй юм¹⁶.

Монгол Улсын Эрхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд тодорхойлсон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны нотолбол зохих асуудлуудын нэг бол гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр¹⁷ байдаг.

Сэдэлт, зорилго нь гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын нэмэгдэл шинжид хамаарагддаг. Хууль тогтоогчийн зүгээс сэдэлт зорилгыг тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх шинж байхаар тодорхойлсон бол энэ нь тухайн гэмт хэргийн субъектив талын өндсөн шинжид тооцогдож, зүйлчлэлд нөлөөлнө.

Гэмт хэргийн сэдэлт гэж гэмт этгээдийн гэмт хэрэг өйлдэх гэсэн гэмт санаа бодлыг бий болгож байгаа, гэмт этгээдийг гэмт хэрэг өйлдэхэд өдүүлн тлхэж байгаа, хор уршигтайгаа харьцах сэтгэл зүйн дотоод харьцаа болох гэм бурууг тодорхойлж байдаг ухамсрын субъектив дотоод хэчин зүйл (сэрэл)-ийг хэлнэ.

Хэргийг барьцаалах гэмт хэрэг шунахайн, түүнчлэн тэр, олон улсын байгууллага, хуулийн этгээд, тодорхой хөндөгс¹⁸ хонзон санасан, танхай, хувийн зэрэг сэдэлттэй байж болно. Тухайлбал, 1988 оны 03-р сарын 08-нд Эрхийн хотын нисэх буудал дээр гар тээш шалгагч С.И.Сергеева эрхийн өрөгт ажилдаа хайнга хандаж Овечкины гэр бүлийн ачааг гүйцэд сайн шалгаагүйгээс ачаанд нуусан зэвсэг, галт хэрэгслийг илрүүлж чадаагүй байна. Энгийн үр дүнд нислэгийн өд 14 цаг 52 минутанд, 11600 метрийн өндөрт Овечкины ах дүүс зэвсэг хэрэглэнэ, бөмбөг дэлбэлнэ гэж сөрдүүлж экипажийг онгоцны нислэгийн чигийг өөрчилж Лондонгийн нисэх буудал дээр буухыг шаардсан. Овечкиныхэнд зэвсэг байгаа ба тэдний санаархал ноцтой болоход итгэсэн экипаж болсон явдлын тухай газар дээрх албанд мэдэгдсэн юм. Удалгүй гэмт хэрэгтнийн шаардлагыг хөдөөн авсан ба онгоцыг шатахуунаар цэнэглэхийн тулд Финляндад буулт хийх болсон тухай тэдэнд мэдэгдсэн байна. Гадаадын нисэх буудал дээр бууж байгаа дүр зөвлөсөн экипаж, онгоцоо Ленинград мужийн Выборг хотын ойролцоо буулгасан байна.

Энэ тухай мэдсэн Овечкиныхон гурван цаг хагасын турш нэн даруй онгоцыг хөргөж ЗХУ-ын хилийг нэвтрэн гарахыг экипажаас шаардсан ба шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд зорчигчдыг устгаж онгоцыг дэлбэлэхээр заналхийлж, тайрсан буугаар онгоцны салонд, мөн нисэгчдийн кабины хаалга руу буудсан. 17 цагийн өд Дмитрий Овечкин барьцаанд байсан өйлчлэгч Т.И.Жаркаяг буудсан аж. 19 цаг 15 минутанд дайрах бөлөг гэмт хэрэгтнийг аюулгүй болгох ажиллагааг явуулсан.

Овечкиныхоны гэмт өйлдлийн үр дагаварт онгоцны өйлчлэгч Т.И.Жаркая болон гурван зорчигч амьдрэгдэж, зорчигчид ба сэргийлэхийн ажилтнуудыг оруулаад 35 хөдөн янз бүрийн хэмжээний гэмтэл авсан байна.

16. Совд Г. БНМАУ-ын Эрхийн эрх зүй дэх гэм буруугийн зарим асуудал. -УБ., 1966. 41 дэх тал.

17. Түүрийн мэдээлэл (эмхтгэл). 2016., № 08

18. Эс, ш гэдэг нь нэг утгатай, хоёр хэлбэртэй үг байна. /Монгол үсгийн дүрмийн толь, Гед. Ц.Дамдинсүрэн. Б.Осор. -УБ., 1983. 6 дахь тал.

Дэлбэрэлтээс өссөн гал тиймрээс болж ТУ-154Б онгоц шатсан ба улсад их хэмжээний хохирол учирсан юм.

Хүнийг барьцаалах гэмт хэрэг дээр зорилго заавал байх шинж байдаг. Сэдэлт, зорилго нь хүний хэрэгцээ, сонирхлоос урган гардаг өөр өөр сэтгэл зүйн агуулгатай, хоорондоо нягт уялдаатай ойлголт юм. Иймд гэмт этгээдийн удирдлага болгосон сэдэлтийг төрний мөн тавьсан зорилготой харьцуулан зэхгүгээр бүрэн ойлгох боломжгүй юм.

Гэмт хэргийн зорилго гэж гэмт этгээдээс гэмт хэрэг үйлдэх явцдаа үйл ажиллагаандаа удирдлага болгож байгаа, гэмт хэрэг үйлдэх замаар хүрч болох эцсийн үр дүнгийн талаарх субъектив төсөөлл, хор уршгийг учруулах гэсэн гэмт этгээдийн эрмэлзлийг хэлнэ.

Барьцаалагч этгээдийн зүгээс төрийг засаглалын байгууллагуудаар нь албадах, төрийн болон бусад байгууллага, эсхүл тодорхой хүнээс мөнгө, бусад эд хүрнэг гаргуулах буюу өөр бусад үйлдэл гүйцэтгүүлэх тэрчлэн үйлдэл гүйцэтгэхээс татгалзуулахыг эрмэлзэж, тодорхой болзол шаардлага тавьж байдаг.

Энэ шаардлага ямар нэгэн үйлдлийг гүйцэтгүүлэхийг, жишээлбэл, хоригдож байгаа этгээдийг суллахыг, тодорхой бус нутгаас цэрэг гаргахыг, онцгой дүрэм журмыг хүчингүй болгох, улс орноос гарч явах, тээврийн хэрэгсэл бүх, барьцаалагдагчийг чөлөөлсний төлөө төлбөрс мөнгө төлөх, үйлдсэн гэмт хэргээ хэрэгсэхгүй болгох гэх мэт зүйлсийг шаардсан байдаг.

Гэмт этгээд ямар нэгэн үйлдлийг гүйцэтгэхгүй байхыг бас шаардаж болдог. Жишээ нь: тодорхой хүний эрхийн хэргийн мөрдөн байцаалтыг сэргээхгүй байх, мансууруулах бодис бэлтгэдэг ба хадгалдаг газрыг эрж хайх ажиллагааг явуулахгүй байхыг, ямар нэгэн баримт бичигт гарын үсэг зуруулахгүй байх гэх мэт. Мөн төвчлэн төрөөс улс төрийн чиг шугамаа өөрчлөх, улс төр, эдийн засаг, нийгмийн шинжтэй ямар нэг шийдвэр гаргуулах, эсхүл гаргахаас татгалзуулах зэрэг зорилгоор хүн барьцаалж болно. Зорилгын агуулга зүйлчлэлд нөлөөлөхгүй юм.

Дүгнэлт

Хүн барьцаалах гэмт хэрэг гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр, тусгай зорилго агуулж үйлдэгддэг, оюун санааны шинж нь гэмт этгээд өөрийн үйлдлийн нийгмийн хор аюулын шинж чанарыг ухамсарлаж, төрний улмаас нийгэмд аюултай хор уршиг учрах нь зайлшгүйг урьдчилан мэдэж байдагт оршдог. Харин хүсэл зоригийн шинж нь гэмт этгээд өөрийн гэмт үйл ажиллагааны улмаас учрах хор уршгийг бий болгохыг хүсэж, төрнийгээ хэрэгжүүлсэн байдгаар илэрч байна.

Хүн барьцаалах гэмт хэргийн объектив талын онцлогууд, үйлдэл, аргын хүрээнд сэдэлт ба зорилго нь хэргийн субьектээс их ч, бага ч сэтгэхүйн болоод сэтгэлийн хүчний хүжлийг шаарддаг. Энэ нь хүн барьцаалах үйлдлийг хэрэг хариуцах чадваргүй хүн үйлдэх бараг боломжгүй болгож байгаа юм. Гэхдээ ямар ч гэсэн хэрэг хариуцах чадваргүй этгээд хүн барьцаалах тохиолдлыг үгүйсгэж болохгүй юм.

Хүн барьцаалах гэмт хэргийн субьектив талыг зөв тогтоосноор тухайн этгээд нь гэм буруутай эсэх, гэм буруугийн ямар хэлбэрээр гэмт хэрэг үйлдсэн, өөрийн гэмт үйл ажиллагаагаа хэрхэн ойлгож ухамсарласан зэрэг гэмт этгээдийн гэмт үйлдэл, эс үйлдэхийдээ хандах сэтгэл зүйн харьцааг тогтоох, тухайн хэрэгт эрхийн хариуцлага хүлээлгэх үндэслэл байгаа эсэх, гэмт этгээдийн үйлдлийг зөв зүйлчлэх, төсөөлөлтэй гэмт хэргүүдийг ялгаж зүйлчлэх, ялыг ялгамжтай оногдуулахад ач холбогдолтой байна.

2015 оны Эрүүгийн хуулийн 13.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хүн барьцаалах гэмт хэргийг “Суллах хүчл болгон тодорхой илдэл хийлгэх, илдэл хийхээс тдгэлзлэхэд тр, байгууллага, хүнийг албадах зорилгоор болзол тулгаж, барьцааны хүнийг алахаар, эрл мэндэд хохирол учруулахаар заналхийлж эрхшээлдээ байлгасан бол...” гэж тодорхойлсон явдал хүн барьцаалах гэмт хэргийн ндсэн брэлдэхүний шинжийг брэн тодорхойлж чадаагүй байна. Онол, практикийн хувьд “гэмт этгээд үрийн ашиг сонирхлыг хангахын тулд хүнийг барьцаалж суллах болзол болгон тр, байгууллага, хүнээр тодорхой илдэл хийлгэх, илдэл хийхээс татгалзуулах зорилго”... тавьж илддэг. үрүр хэлбэл “... гэмт этгээд... тр, байгууллага, хүнийг тодорхой илдэл хийхээс тдгэлзлэх биш (тр зогсох, тр байзнах), хийх илдлээс нь бүр мсн татгалзуулах зорилготой илддэг байна.

Хүн барьцаалах гэмт хэрэг нь гэмт этгээд хүнийг барьж саатуулан, эрх члүг нь хязгаарлан тогтоон барьж, суллах болзол болгон тр, байгууллага, хүнээр тодорхой илдэл хийлгэх, илдэл хийхээс татгалзуулах зорилгоор барьцааны хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж барьцаалсан эрүүгийн хуулиар хориглосон нийгэмд аюултай илдэл хэмээн үзэж байна.

САНАЛ

2015 оны Эрүүгийн хуулийн 13.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүн барьцаалах гэмт хэргийн ндсэн брэлдэхүнд “Барьцаалагдсан хүнийг суллах болзол, шаардлага тулган тодорхой илдэл хийлгэх, илдэл хийхээс татгалзуулахын тулд тр, байгууллага, хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж тогтоон барьсан бол...” гэсэн нэмэлт үрчлүт оруулах санал дэвшүлж байна.

НОМ ЗҮЙ

1. Браинин Я. М. Уголовная ответственность и ее основание в советском уголовном праве. М., 1963
2. Сербский В. П. Судебная психиатрия. Вып. 1. М., 1895
3. Браинин Я. М. Уголовная ответственность и ее основания в советском уголовном праве.
4. Курс советского уголовного права: В 5 т. /Под ред. Н. А. Беляева., М. Д. Шаргородского. Л..Т. 1.1968
5. Гаухман Л. Д. Проблемы уголовно-правовой борьбы с насильственными преступлениями в СССР.
6. Дагель П. С., Котов Д. П. Субъективная сторона преступления и ее установление. Воронеж, 1974
7. Иванов В. Ф. Уголовно-правовая оценка понуждения. Саратов, 1986
8. Рарог А. И. Умысел в формальных преступлениях при приготовлении, покушений и соучастии //Сов. Гос. и право. 1977. №1
9. Никифоров Б. С. Об умысле по действующему уголовному законодательству //Сов. гос. и право. 1965. № 6
10. Vecchi Gregory, M. 2006. Assessing organizational group conflict in law enforcement hostage/barricade management. PhD diss., University of Michigan.
11. Нарангэрэл С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги -УБ., 1999
12. Совд Г. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. -УБ., 1973
13. Совд Г. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүй дэх гэм буруугийн зарим асуудал. -УБ., 1966
14. Содовсүрэн Б. “БНМАУ-ын Эрүүгийн эрх” ерөнхий анги. -УБ. 1969
15. С, Ш гэдэг нь нэг утгатай, хоёр хэлбэртэй үг байна. /Монгол үсгийн дүрмийн толь, Гед.
16. Ц.Дамдинсүрэн. Б.Осор. -УБ., 1983
17. Түрийн мэдээлэл.(эмхтгэл) -УБ., 2016. № 07
18. Түрийн мэдээлэл (эмхтгэл). 2016., № 08